

# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН НУТАГТ ОРШИХ ТОЛГОЙТ-1 ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### Ерөнхий мэдээлэл

“Чамин алт” ХХК нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших 25.0 га талбай бүхий Толгойт-1 алтны шороон ордын MV-012469 тоот тусгай зөвшөөрлийг АМГТХЭГ-ын 2008 оны 06-р сарын 17-ны өдөр авсан байдаг. Тус талбайд хайгуулын ажлыг өөрийн хөрөнгөөр явуулж нөөцийг улсын нэгдсэн санд бүртгүүлсэн байна. Чамин Алт ХХК нь алтны шороон ордод үйл ажиллагаа явуулж байсан ба ажиллах хүчин болон олборлолтын арвин туршлагатай байна.

### Төслийн нэр :

- *Толгойтын хөндийн Толгойт-1 алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл*

### Төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгж, байгууллагын нэр:

- “ЧАМИН АЛТ”ХХК
  - Улсын бүртгэлийн дугаар : 9019043029
  - Регистрийн дугаар : 5231337

### Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

- *Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуур, Шинэ Улаанбаатар хотхон 1004-48 тоот*
  - Утас: 976-98885188. 85855188
  - Цахим хаяг: chaminalt98@gmail.com

### Төслийн зорилго :

- *Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших Толгойт-1 MV-012469 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах бодитой В зэргийн геологийн нөөц хими цэврээр 79.0кг алтны нөөцөд тулгуурлан уг ордыг ашиглах төсөл боловсруулан ордыг аж ахуйн эргэлтэнд оруулж улс орны төсөвт өөрийн хувь нэмрээ оруулах ажлын байр бий болгох уул уурхайн салбарыг хөгжүүлэх зэрэгт оришино.*

### Төсөл хэрэгжих үе шат

- *Ашиглалтын 2 жил*

# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН НУТАГТ ОРШИХ ТОЛГОЙТ-1 ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## Төслийн байршил

Толгойтын хөндийн Толгойт-1 алтны шороон орд нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах бөгөөд Улаанбаатар хотоос 450 км-т, Дархан хотоос 200 км-т, Бугант тосгоноос зүүн хойд зүгт 5 км зайд Толгойт, Сангийн гол, Шавартын голын уулзвараас баруун урагш 2 км-т оршино.

- Талбайн байр зүйн зургийн хавтгай : М-48-95
- Талбайн хэмжээ : 25 га
- Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар : MV-012469


*Хүснэгт 1. Талбайн булангийн цэгүүдийн солиболзол*

| MV-012469 Толгойт-1 |                 |                |    |                 |               |
|---------------------|-----------------|----------------|----|-----------------|---------------|
| №                   | Уртраг          | Өргөрөг        | №  | Уртраг          | Өргөрөг       |
| 1                   | 107° 21' 15.41" | 49° 28' 1.91"  | 52 | 107° 20' 30.3"  | 49° 27' 1.7"  |
| 2                   | 107° 21' 10.45" | 49° 28' 1.91"  | 53 | 107° 20' 30.3"  | 49° 27' 2.3"  |
| 3                   | 107° 21' 10.23" | 49° 27' 57.52" | 54 | 107° 20' 31.33" | 49° 27' 2.3"  |
| 4                   | 107° 21' 7.25"  | 49° 27' 57.59" | 55 | 107° 20' 31.33" | 49° 27' 2.91" |
| 5                   | 107° 21' 7.17"  | 49° 27' 55.64" | 56 | 107° 20' 32.4"  | 49° 27' 2.91" |
| 6                   | 107° 21' 5.19"  | 49° 27' 55.68" | 57 | 107° 20' 32.4"  | 49° 27' 3.52" |
| 7                   | 107° 21' 5.08"  | 49° 27' 53.43" | 58 | 107° 20' 33.4"  | 49° 27' 3.52" |
| 8                   | 107° 21' 2.6"   | 49° 27' 53.47" | 59 | 107° 20' 33.4"  | 49° 27' 4.12" |
| 9                   | 107° 21' 2.49"  | 49° 27' 51.22" | 60 | 107° 20' 34.42" | 49° 27' 4.12" |
| 10                  | 107° 20' 59.01" | 49° 27' 51.29" | 61 | 107° 20' 34.42" | 49° 27' 4.73" |
| 11                  | 107° 20' 58.49" | 49° 27' 40.29" | 62 | 107° 20' 35.46" | 49° 27' 4.73" |
| 12                  | 107° 20' 57.5"  | 49° 27' 40.3"  | 63 | 107° 20' 35.46" | 49° 27' 5.34" |
| 13                  | 107° 20' 57.39" | 49° 27' 38.37" | 64 | 107° 20' 36.46" | 49° 27' 5.34" |
| 14                  | 107° 20' 55.92" | 49° 27' 38.39" | 65 | 107° 20' 36.5"  | 49° 27' 5.94" |
| 15                  | 107° 20' 55.84" | 49° 27' 36.77" | 66 | 107° 20' 38"    | 49° 27' 6.57" |
| 16                  | 107° 20' 53.35" | 49° 27' 36.83" | 67 | 107° 20' 38.53" | 49° 27' 7.18" |
| 17                  | 107° 20' 52.93" | 49° 27' 27.78" | 68 | 107° 20' 39.5"  | 49° 27' 7.18" |
| 18                  | 107° 20' 50.43" | 49° 27' 27.82" | 69 | 107° 20' 39.5"  | 49° 27' 7.79" |
| 19                  | 107° 20' 50.25" | 49° 27' 23.95" | 70 | 107° 20' 40.55" | 49° 27' 7.79" |
| 20                  | 107° 20' 47.78" | 49° 27' 24"    | 71 | 107° 20' 40.55" | 49° 27' 8.37" |
| 21                  | 107° 20' 47.62" | 49° 27' 20.76" | 72 | 107° 20' 41.6"  | 49° 27' 8.37" |
| 22                  | 107° 20' 45.64" | 49° 27' 20.8"  | 73 | 107° 20' 41.6"  | 49° 27' 9"    |
| 23                  | 107° 20' 45.5"  | 49° 27' 17.89" | 74 | 107° 20' 42.6"  | 49° 27' 9"    |
| 24                  | 107° 20' 44"    | 49° 27' 17.92" | 75 | 107° 20' 42.6"  | 49° 27' 9.6"  |
| 25                  | 107° 20' 43.92" | 49° 27' 15.98" | 76 | 107° 20' 43.64" | 49° 27' 9.6"  |
| 26                  | 107° 20' 42.42" | 49° 27' 16.01" | 77 | 107° 20' 43.64" | 49° 27' 10.2" |


**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН НУТАГТ ОРШИХ ТОЛГОЙТ-1 ОРДЫН 2025  
ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

|    |                 |                |     |                 |                |
|----|-----------------|----------------|-----|-----------------|----------------|
| 27 | 107° 20' 42.27" | 49° 27' 12.78" | 78  | 107° 20' 44.7"  | 49° 27' 10.2"  |
| 28 | 107° 20' 41.27" | 49° 27' 12.79" | 79  | 107° 20' 44.7"  | 49° 27' 11.7"  |
| 29 | 107° 20' 41.17" | 49° 27' 10.53" | 80  | 107° 20' 45.75" | 49° 27' 11.7"  |
| 30 | 107° 20' 39.18" | 49° 27' 10.57" | 81  | 107° 20' 45.75" | 49° 27' 13.43" |
| 31 | 107° 20' 39.11" | 49° 27' 8.95"  | 82  | 107° 20' 46.8"  | 49° 27' 13.43" |
| 32 | 107° 20' 36.13" | 49° 27' 9.02"  | 83  | 107° 20' 46.8"  | 49° 27' 15.16" |
| 33 | 107° 20' 36.01" | 49° 27' 6.42"  | 84  | 107° 20' 49.85" | 49° 27' 15.16" |
| 34 | 107° 20' 33.03" | 49° 27' 6.49"  | 85  | 107° 20' 49.85" | 49° 27' 17.38" |
| 35 | 107° 20' 32.96" | 49° 27' 4.87"  | 86  | 107° 20' 54.91" | 49° 27' 17.38" |
| 36 | 107° 20' 30.48" | 49° 27' 4.92"  | 87  | 107° 20' 54.91" | 49° 27' 17.38" |
| 37 | 107° 20' 30.39" | 49° 27' 3.3"   | 88  | 107° 20' 56.39" | 49° 27' 17.34" |
| 38 | 107° 20' 25.44" | 49° 27' 3.4"   | 89  | 107° 20' 57.23" | 49° 27' 34.81" |
| 39 | 107° 20' 24.75" | 49° 26' 48.84" | 90  | 107° 21' 1.2"   | 49° 27' 34.73" |
| 40 | 107° 20' 31.19" | 49° 26' 48.72" | 91  | 107° 21' 1.4"   | 49° 27' 38.93" |
| 41 | 107° 20' 31.31" | 49° 26' 51.3"  | 92  | 107° 21' 3.38"  | 49° 27' 38.9"  |
| 42 | 107° 20' 35.28" | 49° 26' 51.22" | 93  | 107° 21' 3.79"  | 49° 27' 47.29" |
| 43 | 107° 20' 35.38" | 49° 26' 53.26" | 94  | 107° 21' 4.78"  | 49° 27' 47.28" |
| 44 | 107° 20' 26.07" | 49° 26' 53.26" | 95  | 107° 21' 4.82"  | 49° 27' 48.24" |
| 45 | 107° 20' 26.07" | 49° 26' 59.8"  | 96  | 107° 21' 7.31"  | 49° 27' 48.2"  |
| 46 | 107° 20' 27.3"  | 49° 26' 59.8"  | 97  | 107° 21' 7.44"  | 49° 27' 51.11" |
| 47 | 107° 20' 27.3"  | 49° 27' 0.5"   | 98  | 107° 21' 8.94"  | 49° 27' 51.08" |
| 48 | 107° 20' 28.3"  | 49° 27' 0.5"   | 99  | 107° 21' 9.08"  | 49° 27' 53.98" |
| 49 | 107° 20' 28.3"  | 49° 27' 1.11"  | 100 | 107° 21' 12.06" | 49° 27' 53.92" |
| 50 | 107° 20' 29.3"  | 49° 27' 1.11"  | 101 | 107° 21' 12.15" | 49° 27' 56.19" |
| 51 | 107° 20' 29.3"  | 49° 27' 1.7"   | 102 | 107° 21' 15.13" | 49° 27' 56.12" |

# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН НУТАГТ ОРШИХ ТОЛГОЙТ-1 ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг



Зураг 2. Агаар сансарын зураг

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН НУТАГТ ОРШИХ ТОЛГОЙТ-1 ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Газрын гадаргуу:** Төслийн нутаг дэвсгэр нь Хэнтийн нурууны баруун хойд хажууд байрлах ба дунд зэрэг өргөгдсөн гадаргуутай.

**Усан сүлжээ:** Талбайн хэмжээнд гадаргуугийн усан сүлжээ зонхилох бөгөөд эдгээрээс хамгийн том нь Ерөө гол ба ашиглалтын талбайгаас хамгийн ойр цэг нь 10 км орчим зайтай байдаг. Тусгай зөвшөөрлийн талбай нь Толгойтын, Сангийн голын хөндийд оршино. Орчин үеийн уур амьсгалын нөхцөлөөс хамаарч Сангийн гол, Шавартын голууд ширгэж, шургасан байдаг. Харин Толгойтын гол нь хуучин ашиглалтанд өртсөн талбайнуудыг дайран өнгөрч уг тусгай зөвшөөрлийн талбайн баруун талаар урсан өнгөрнө. Ус зүйн хувьд Хойд мөсөн далайн ай сав, Ерөө голын сав газарт тус тус багтана. Энэ ай савд Монгол орны гол мөрний усны нөөцийн 49% бүрддэг.

**Цаг агаар:** Талбай нь эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсэд хамаарах бөгөөд жилийн дулааны хэлбэлзэл  $+30^{\circ}\text{C}$ -с  $-50^{\circ}\text{C}$  -ийн хооронд хэлбэлздэг. Зундаа 20-25 хэм дулаан, өвөлдөө 35 хэм хүртэл хүйтэрдэг. Жилд дунджаар 350-500 мм-ийн хур тунадас буух боловч ихэнх нь өвөл, зуны улиралд ордог. Хур тунадасны ихэнх хувийг бороо эзэлдэг ба бараг 80 % хүрнэ. Анхны цас 10-р сараас эхлэх бөгөөд 4-р сар хүртэл үргэлжилдэг. Цасан гадаргуугийн зузаан дунджаар 0.15 м хүрдэг. Харин өвлийн улиралд газрын гадаргуу 2.0-3.0 м гүн хүртэл хөлддөг байна. Газрын гадаргуу 10-р сарын сүүлчээр хөлдөж 5-р сарын сүүлчээр гэсдэг. Агаарын харьцангуй чийгшилт 47-55 хувь байна.

**Амьтны аймаг:** Хангайн уулархаг бүсэд тохиолддог ойд амьдардаг ан амьтад элбэг тохиолддог ба тухайлбал гөрөөс, зэрлэг гахай, баавгай, чоно, туулай гэх мэт. Мэрэгчдээс хэрэм, жирх, зурам элбэг тохиолддог. Гэвч тусгай зөвшөөрлийн талбай орчимд уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа жил бүр явагддаг тул ан амьтан талбайн орчимд тааралдахгүй.

**Хөрс бүрхэвч, ургамлан нөмрөг:** Хөрсний мужлалаар ойт хээрийн бүсийн ялзмаг ихтэй үржил шимт хар хүрэн ба хүрэн бор хөрс зонхилсон нутагт багтдаг. Тусгай зөвшөөрлийн талбайд хангайн бүсэд ургадаг ургамал, бутлаг ургамал, жижиг торлогууд

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН НУТАГТ ОРШИХ ТОЛГОЙТ-1 ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

тааралдана. Хангайн бүсэд ургадаг нарс, хар мод, хус мод тусгай зөвшөөрлийн талбайд тааралдахгүй. Харин голын хөндийн өвслөг ургамал элбэг тохиолдоно. Бугантын дүүрэг нь тэр тусмаа Толгойтын голын хөндий нь маш олон төрөл зүйлийн олон наст ургамалаар баялаг юм. Тус талбайд хонгорзул, юмдүүжин, далийн ягаан зэрэг маш олон төрлийн цэцэг болон ойн өвслөг ургамлууд мөн монос, нохойн хошуу, бөөрөлзгөнө, улаазгана зэрэг жимсний моднууд, хус, нарс, бургас, хуш гэх мэт модлог ургамлууд голчлон ургадаг.

**Түүх дурсгалт газар болон олдвор:** Бүхлээн хүн чулуу, Ялбагийн чулуун хөшөө, Дарь эхийн сүм, Далангийн дуган, Ходоодын хийд, Хадны ламын дуганы үлдэгдэл туурь, Гүн толгойн шавраар бурхан хийж шатааж байсан газар зэргийг дурьдаж болно. Ерөө сумын хэмжээнд 2010 оны улсын тооллогоор түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох хийдийн туурь-1, хиргисүүр-43, булш-95, бурхан цутгаж байсан газрын туурь-1, суварга-3, суварганы туурь-8 дурсгалын хөшөө-1, хотын туурь-1 нийт 153 бүртгэгдсэн.

**Эдийн засаг, зам харилцаа:** Толгойтын хөндийн Толгойт-1 алтны шороон орд нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотоос 450 км зайтай. Тусгай зөвшөөрлийн талбай нь газарзүй, эдийн засгийн хувьд дэд бүтэц сайн хөгжсөн. Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах ба Дархан-Уул аймгийн төвөөс зүүн хойш 200 км зайд орших бөгөөд авто замын сүлжээ сайн хөгжсөн, гол авто зам нь ердийн шороон зам байдаг. Толгойтын гол, Сангийн гол, Шавартын голын уулзварт, Толгойтын алтны шороон ордын доод хэсэгт байрладаг. Мөн Бугант тосгоноос Хүдэр сум хүртэлх өндөр хүчдэлийн шугам (35 мян.квт) нь ордын хажуугаар өнгөрдөг. Төв суурин газруудад эмнэлэг, сургууль, харилцаа холбоо, засаг захиргааны нэгж, дэлгүүр, хувийн үйлчилгээний газрууд гэх мэт байгууллагуудтай. Хамгийн ойр орших суурин газар нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгон бөгөөд ордоос баруун урагш 3 км зайд оршино.

## **СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН НУТАГТ ОРШИХ ТОЛГОЙТ-1 ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

### **Уурхайн ашиглалтын системийн сонголт**

#### **Ордын уул-техникийн нөхцөл**

Толгойт-1 алтны шороон ордын элсний (ашигт) давхрага сунаж тогтсон ба давхрагын өргөн дунджаар 150 м болно. Ордын хөрс хуулалтын зузаан дунджаар 18.7 м гэж тогтоосон. Ашигт (элсний) давхрагын зузаан дунджаар 1.85 м байна.

Алт агуулсан давхрага элс, шаварлаг элсэрхэг дүүргэгчтэй, аллювиаль-пролювиаль хурдсаар дүүргэгдсэн. Алттай давхрага нь олон жилийн хөлдүү хөрсгүй. Ордын ашигт давхрагыг бүрдүүлэгч хурдсын литологийн найрлагат шаварлаг хольцын агуулга 10 %- иас ихгүй учир элсний угаагдах чанар сайтай.

Толгойт-1 алтны шороон ордын олборлолтонд бэлтгэгдсэн ашиглалтын талбайд хамаарах геологийн нөөц, элс  $160.5 \text{ мян.м}^3$ , хөрс  $1616.7 \text{ мян.м}^3$ , алт 86.24 кг /шлих/, сорьц тооцсоноор 79.0 кг тогтоогдсон байна.

#### **Ордын нөөцийн тооцоо**

Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоогоор бохирдлыг улнаас 25 см, таазнаас 20 см байхаар тооцоход  $27.5 \text{ мян.м}^3$  буюу 24.06 % байна. Төсөлд алт хаяхгүй байхаар тооцсон ба төсөл хэрэгжих хугацаанд ордоос нийт  $136.42 \text{ мян.м}^3$  хөрс хуулж, үүнээс  $2.26 \text{ мян.м}^3$  өнгөн хөрс хуулж шимт хөрсний овоолгод байршуулах бөгөөд дунджаар  $340 \text{ мг/м}^3$  агуулгатай шлихээр 4.06 кг, хими цэврээр . кг алттай  $13.11 \text{ мян.м}^3$  элс олборлохоор тооцжээ.

### **Уурхайн ажиллах горим ба ашиглалтын хугацаа**

Уурхайн ажиллах горим нь манай орны улирлын шинж чанар, цаг агаар, уур амьсгал, ил уурхайн үндсэн техник тоног төхөөрөмжийн бүтээл, уурхайн жилийн хүчин чадал зэргээс ихээхэн шалтгаална.

Уурхай нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулах учир олборлолт явуулах үед тасралтгүй ажиллана. Улсын чанартай баяр ёслолын өдрүүдэд амарна. Харин техник

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН НУТАГТ ОРШИХ ТОЛГОЙТ-1 ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

тоног төхөөрөмжүүдэд үзлэг үйлчилгээ, урсгал засвар хийх хоногийн тоо сард 2 өдөр байхаар төсөлд төлөвлөсөн байна.

*Хүснэгт 2. Уурхайн ажиллах горим*

| д/д | Үзүүлэлтүүд                        | Хэмжих нэгж | 2025 он |
|-----|------------------------------------|-------------|---------|
| 1   | Жилд ажиллах боломжит хоног        | хоног       | 210     |
| 2   | Амралт, баяр ёслолын хоног         | хоног       | 4       |
| 3   | Цаг агаарын хүндрэлтэй хоног       | хоног       | 8       |
| 4   | Уурхайн ажиллах ажлын хоног        | хоног       | 120     |
| 5   | Урсгал засвар хийгдэх хоног        | хоног       | 12      |
| 6   | Уурхайн бэлтгэл ажил хийгдэх хоног | хоног       | 10      |
| 7   | Хөрс хуулах боломжит хоног         | хоног       | 110     |
| 8   | Элс угаах боломжит хоног           | хоног       | 110     |
| 9   | Нэг хоног дах ээлжийн тоо          |             | 2       |
| 10  | Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа цаг  | цаг         | 10      |

Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө: Алтны шороон ордын уулын ажлын календарчилсан төлөвлөгөөг элс угаах тоног төхөөрөмж болон олборлох техник тоног төхөөрөмжийн хүчин чадлаас хамааруулан дараах байдлаар төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө*

| Үзүүлэлтүүд      | Хэмжих нэгж        | 2025 он | Нийт   |
|------------------|--------------------|---------|--------|
| Хөрс хуулалт     | мян.м <sup>3</sup> | 136.42  | 136.42 |
| Элс олборлолт    | мян.м <sup>3</sup> | 13.11   | 13.11  |
| Дундаж агуулга   | мг/м <sup>3</sup>  | 340     | 340    |
| Алт /хими цэвэр/ | кг                 | 4.06    | 4.06   |

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН НУТАГТ ОРШИХ ТОЛГОЙТ-1 ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### Ил уурхайн ашиглалтын систем

Уг орд нь ашиглалтын гүн их биш, уул-геологийн нөхцөл харьцангуй энгийн тул тээвэртэй ашиглалтын системээр ил аргаар ашиглах нь хамгийн тохиромжтой юм. Иймд шимт хөрсийг хуулсаны дараагаар хөрс, элсний давхаргыг экскаватор автосамосвалын хослолоор, хөрсийг эхний үед хөрсний гадаад овоолгод тээвэрлэх ба элс олборлосны дараагаар дотоод овоолго үүсгэхээр төлөвлөлөө. Харин алт агуулсан элсийг скруббер байрласан талбайд зөөвөрлөхөөс гадна скрубберээр угаагдан гарсан эфель, галийг бульдозероор түрж, тэгшлэн хэлбэршүүлж өнгөн хөрсөөр хучиж нөхөн сэргээлт хийнэ.

*Хүснэгт 4. Ашиглалтын системийн элементүүд*

| №                 | Үзүүлэлтүүд                                                  | Нэгж | Тэмдэглэгээ    | Тоо, хэмжээ |
|-------------------|--------------------------------------------------------------|------|----------------|-------------|
| 1                 | Хөрсний доголын өндөр                                        | м    | Н              | 5           |
| 2                 | Дээд доголын хормойгоос замын тэнхлэг хүртэлх зай            | м    | С <sub>1</sub> | 3.0         |
| 3                 | Авто замын тэнхлэг хоорондын зай                             | м    | Е              | 4.5         |
| 4                 | Замын тэнхлэгээс доод доголын ирмэгийн нурах хил хүртэлх зай | м    | С <sub>2</sub> | 3.0         |
| 5                 | Доод доголын ирмэгийн нурах өргөн                            | м    | Вн             | 1.5         |
| 6                 | Автозамын өргөн                                              | м    | Тө             | 12          |
| Бусад үзүүлэлтүүд |                                                              |      |                |             |
| 7                 | Олборлолтын доголын өндөр                                    | м    | h              | 1.4         |
| 8                 | Доголын налуугийн өнцөг                                      | Град | α              | 50          |
| 9                 | Орлын өргөн                                                  | м    | Аор            | 16          |
| 10                | Ажлын талбайн өргөн                                          | м    | Ват            | 10-25       |
| 11                | Авто замын налуу                                             | ‰    |                | 60-80       |

**Угаан баяжуулах цехийн технологи ба ажиллах горим.** Ордын элсийг угаан баяжуулах цехийн жилийн хүчин чадал 84.2 мян.м<sup>3</sup> ба тоног төхөөрөмжийн ашиглалт 100%-тай ажиллах үед цагийн хүчин чадал 40.0 м<sup>3</sup> байна. Дараах хүснэгтэд баяжуулах цехийн ажиллах горимыг үзүүлэв.

Элс угаан баяжуулах цех нь уул-техникийн шинж чанараас хамаарч ажиллах ба зөвхөн дулааны улиралд буюу 6-р сарын 10-ээс 10-р сарын 01-ны хооронд ажиллана. Үүнээс угаах төхөөрөмжийн хүчин чадал болон амралтын өдөр, сул зогсолт зэргээс

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН НУТАГТ ОРШИХ ТОЛГОЙТ-1 ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

хамааран 90-117 хоног ажиллахаар төлөвлөсөн. Элс угаан баяжуулах цехийн хувьд алт агуулсан элсийг угаах тоног төхөөрөмжийн бүтээлээс хамаарч хоногт 2 ээлжээр, 10 цаг ажиллана.

*Хүснэгт 5. Элс угаан баяжуулах цехийн ажиллах горим*

| №  | Ажиллах горим                               | 2025  |
|----|---------------------------------------------|-------|
| 1  | Жилийн хуанлийн хоногийн тоо                | 365   |
| 2  | Жилийн хуанлийн цаг                         | 8760  |
| 3  | Хоногийн хуанлийн цаг                       | 24    |
| 4  | Цаг ашиглалт, %                             | 75    |
| 5  | Ээлжинд ажиллах цаг                         | 10    |
| 6  | Хоногт ажиллах ээлжийн тоо                  | 2     |
| 7  | Жилд ажиллах цаг                            | 2114  |
| 8  | Жилд ажиллах хоног                          | 117   |
| 9  | Цагийн хүчин чадал, м <sup>3</sup> /цаг     | 40.0  |
| 10 | Хоногийн хүчин чадал, м <sup>3</sup> /хоног | 720.0 |
| 11 | Жилийн хүчин чадал, мян.м <sup>3</sup> /жил | 84.2  |

*Хүснэгт 6. Нийт бүтээгдэхүүн гаргалт*

| № | Үзүүлэлт                             | Нэгж                    | 2025 он | Нийт    |
|---|--------------------------------------|-------------------------|---------|---------|
| 1 | Нийт баяжуулах элс                   | мян.м <sup>3</sup> /жил | 13.11   | 13.11   |
| 2 | Элсэн дэх алтны агуулга, /дундаж/    | гр/м <sup>3</sup>       | 0.340   | 0.340   |
| 3 | Элсэн дэх алтны хэмжээ               | кг                      | 4.45    | 4.45    |
| 4 | Алтны баяжмалын гарц, /дундаж/       | %                       | 0.0001  | 0.0001  |
| 5 | Баяжмал дахь алтны агуулга, /дундаж/ | гр/м <sup>3</sup>       | 3123.08 | 3123.08 |
| 6 | Металл авалт, /дундаж/               | %                       | 91.20   | 91.20   |
| 7 | Баяжмал дахь алт                     | кг                      | 4.06    | 4.06    |

Элсийг гравитацийн аргаар скруббер-тунах машины хослолоор угаан ангилах, баяжуулах ширээгээр гүйцээн баяжуулан 91.2 %-ийн металл авалттайгаар нийтдээ шлихээр 4.45 кг, хими цэврээр 4.06 кг алт баяжуулж авахаар тооцсон. Элс угаан баяжуулах явцад хаягдах алтны хэмжээг бууруулах, металл авалтыг туршилтын үр дүнд

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН НУТАГТ ОРШИХ ТОЛГОЙТ-1 ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

хүргэх болон сайжруулах зорилгоор баяжуулах ширээний хаягдалд хяналтын сорьцолтыг байнга хийж хаягдалд алт алдагдаж буй эсэхийг хянаж ажиллана.

### **Төслийн техник тоног төхөөрөмж, дэд бүтцийн хангамж**

Тус төслийн хөрс хуулах, элс олборлолтын ажилд жилд 2 ш Doosan 520 маркийн экскаватор, хөрс, элс тээвэрлэх ажилд /дундаж зай 0.8 км/ Howo маркийн 12 м<sup>3</sup>-ийн тэвшний багтаамжтай автосамосвал 10 ш, овоолгыг бөөгнүүлэх, угаах төхөөрөмжийг элсээр тэжээх болон угаагдаж гарсан эфель, гаалийг автосамосвалд ачих зэрэг ажиллагаанд БНХАУ-д үйлдвэрлэсэн ZL-50 маркийн 3.0 м<sup>3</sup> шанаганы багтаамж бүхий утгуурт ачигч 2ш, шимт хөрс хуулах, хөрсний овоолго түрж тэгшлэх, хуулсан хөрсийг ашигласан орон зайд түрж оруулах тэгшлэх, нөхөн сэргээлтэнд ажиллах, зам засах, зэрэг ажлуудад SD-32 бульдозер 1 ш байна.

HOWO Маркийн автосамосвал



XG951 маркийн утгуурт ачигч



SD-32 маркийн бульдозер

Doosan 520 Маркийн урвуу утгуурт экскаватор



CB-40 маркийн скруббер



СКМ-1А Баяжуулах ширээ

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН НУТАГТ ОРШИХ ТОЛГОЙТ-1 ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



*JT5-2 Тунаах машин*



*140TSWA Эргэлтийн усны насос*



*Зураг 4. Ил уурхай болон элс угаах техник тоног төхөөрөмжийн*

*Хүснэгт 7. Төслийн техник тоног төхөөрөмжийн хүчин чадлын тойм үзүүлэлтүүд*

| № | Техникийн нэр төрөл | Техникийн марк | Тоо хэмжээ, ш | Техникийн үзүүлэлт                       |                              |                                       |
|---|---------------------|----------------|---------------|------------------------------------------|------------------------------|---------------------------------------|
|   |                     |                |               | Нэгж ажлын багтаамж, м <sup>3</sup> (тн) | Явах хамгийн их хурд, км/цаг | Жилийн бүтээлийн норм, м <sup>3</sup> |
| 1 | Автосамосвал        | Howo-ZZ331     | 2             | 25                                       | 80                           | 85.7                                  |
| 2 | Утгуурт ачигч       | ZL-50          | 1             | 3.0                                      | 16.7                         | 149.7                                 |
| 3 | Бульдозер           | SD-32          | 1             | 10                                       | 6.6                          | 313.7                                 |
| 4 | Экскаватор          | Doosan 520     | 1             | 3.0                                      | 5.2                          | 139.5                                 |
| 5 | Скрubber            | CB-40          | 1             | 20-40м <sup>3</sup> /цаг                 |                              |                                       |

### Дэд бүтэц, барилга байгууламжууд

Хаягдлын санд эргэлтийн усны систем ашиглан угаах төхөөрөмжийн хаягдалтай хамт хаягдсан усыг тунгааж эргүүлэн угаах төхөөрөмжүүдийг эргэлтийн усаар хангана. Элс угаан баяжуулахад шаардагдах усыг тооцвол 1 м<sup>3</sup> элс угаахад 4.0 м<sup>3</sup> ус шаардагдана. Элс угаан баяжуулахад шаардлагатай усны 70%-ийг эргэлтийн усаар, 30 %-ийг цэвэр усаар хангана

### Усан хангамж:

Элс угаах тоног төхөөрөмжийн хувьд хүндийн хүчээр ангилан ялгах скруббер болон тунаах машины хослол болох 1 ш CB-40 маркийн скруббер, 1 ш JT5-2 маркийн

## **СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН НУТАГТ ОРШИХ ТОЛГОЙТ-1 ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

тунаах машин, гүйцээн баяжуулалтанд Holman 8000 маркийн баяжуулах ширээ гэсэн үндсэн тоног төхөөрөмжийг ашиглана.

Ордын элсийг угаан баяжуулах цехийн жилийн хүчин чадал 13.11 мян.м<sup>3</sup> ба тоног төхөөрөмжийн ашиглалт 100%-тай ажиллах үед цагийн хүчин чадал 40.0 м<sup>3</sup> байна.

### **Уурхайн цахилгаан хангамж**

Толгойт-1 алтны уурхайн цахилгааны гол хэрэглэгч нь угаах төхөөрөмж, усны насос, засварын цех, уурхайн тосгон болон бусад жижиг хэрэглэгчид байх ба Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК-ийн Сэлэнгэ аймгийн Бугант тосгоны 110/6 кВ-ын Толгойт дэд станцын 6 кВ-ын хуваарилах байгууламжийн ячейк №7-ын агаарын шугамын тулгуур №20-аас салбарлуулан 0.6 км урт агаарын шугам татна.

### **Уурхайн ажиллах хүч**

Уурхайд жилд дунджаар 32 хүн ажиллах юм. Тасралтгүй ажиллагааг хангахын 2 ээлжээр ажиллана. Нэг ээлж 10 цаг ажиллаж байхаар төлөвлөсөн.

### **Уурхайн тээвэр**

Толгойтын хөндийн алтны уурхайн хөрс тээвэрлэх ажилд 12 м<sup>3</sup>-ийн тэвшний багтаамжтай БНХАУ-д үйлдвэрлэсэн HOWO маркийн автосамосвалыг ажиллуулахаар төлөвлөсөн байна. Ил уурхайн хөрс болон элс тээвэрлэх зай дунджаар 1.2 км байна.

### **Хөрөнгө оруулалтын хэмжээ /сая.төг**

Улс болон орон нутгийн төсөвт төлөх татвар төлбөрүүд. Тус уурхайг ажиллуулснаар улс, орон нутгийн төсөвт 2025 онд 139.09 сая.төг төлөх ба энэ нь нийт борлуулалтын орлогын 11.6 хувийг эзэлж байна.

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН НУТАГТ ОРШИХ ТОЛГОЙТ-1 ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

#### Төслөөс нийгэм-эдийн засагт үзүүлэх болзошгүй нөлөөлөл

Толгойтын хөндийн Толгойт-1 алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл хэрэгжсэнээр орон нутгийн нийгэм-эдийн засагт дараах нөлөөллийг үзүүлэх боломжтой.

*Хүснэгт 8. Төслөөс орон нутгийн нийгэм-эдийн засагт үзүүлэх болзошгүй нөлөөлөл*

| Нийгэм-эдийн засгийн үзүүлэлт | Төслөөс үзүүлэх нөлөө                                                                                                                                                                                                                                                                                                                         |
|-------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Ажил эрхлэлт                  | Төслийн үйл ажиллагааны үед орон нутагт түр ажлын байр бий болно.                                                                                                                                                                                                                                                                             |
| Зах зээл                      | Ханган нийлүүлэх эрэлт ихээр үүсэх тул орон нутагт хуваарилах боломжтой. Үүнд: <ul style="list-style-type: none"><li>• Хүнсний хангамж, худалдаа</li><li>• Ажлын хувцас ахуйн хангамж</li><li>• Түлш шатахуун сэлбэг хэрэгсэл</li></ul>                                                                                                       |
| Татвар төсөв                  | Орон нутгийн төсөвт дараахи татваруудыг төлнө.<br>Үүнд : <ul style="list-style-type: none"><li>• НӨАТ</li><li>• ХАОАТ</li></ul> Байгаль орчны дараахи төлбөр хураамж төлнө.<br>Үүнд : <ul style="list-style-type: none"><li>• Газар ашигласны төлбөр</li><li>• Ус ашиглалтын төлбөр</li><li>• Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр</li></ul> |

#### Байршилтай холбоотой төслийн нөлөөллийн цар хүрээ

Төслийн нөлөөллийн бүсэд тусгай хамгаалалттай газар нутаг хамрагдаагүй, төслөөс үзүүлэх нөлөө өөрөө зохицуулагдах хэлбэртэй, нөлөөллийн үр дагаврын үнэлгээгээр бага буюу сөрөг нөлөөгүй байна.

Хуулиар хамгаалагдсан талбай, түүх соёлын дурсгалт болон үнэт биет зүйлс төслийн талбайгаас ихээхэн хол байршилтай зэрэг нөхцөл байдлаас төслөөс үзүүлэх сөрөг нөлөө эрчим багатай, өөрөө цэгцрэн зохицуулагдах боломж ихтэй байна.

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН НУТАГТ ОРШИХ ТОЛГОЙТ-1 ОРДЫН 2025  
ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

*Хүснэгт 9.Байршилтай холбоотой төслийн нөлөөллийн үзүүлэлт*

| Сөрөг нөлөөлөл                                                                                                                                          | Нөлөөлийн хэлбэр |          |                     | Нөлөөллийн үнэлгээ |      |          |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------|----------|---------------------|--------------------|------|----------|
|                                                                                                                                                         | Шууд             | Шууд бус | Өөрөө зохицуулагдах | Бага буюу нөлөөгүй | Дунд | Эрчимтэй |
| Хуулиар хамгаалагдсан газар нутагт үзүүлэх нөлөө                                                                                                        |                  |          |                     |                    |      |          |
| Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт нийт арван хоёр орон нутгийн тусгай хамгаалалтай газар нутаг байна. Төслийн талбай нь ОНТХГНутагтай давхцалгүй болно. |                  |          | х                   | х                  |      |          |
| Төсөл хэрэгжих нутгийн эмзэг байдалд үзүүлэх нөлөө                                                                                                      |                  |          |                     |                    |      |          |
| Орон нутгийн салхи тогтворгүйгээс үүсэх нөлөө                                                                                                           |                  |          | х                   |                    | х    |          |
| Жилд орох хур тундас их                                                                                                                                 |                  |          | х                   | х                  |      |          |
| Газар ашиглалтын байдалд үзүүлэх нөлөө                                                                                                                  |                  |          |                     |                    |      |          |
| Бүтээн байгуулалт төлөвлөсөн газар байхгүй                                                                                                              |                  |          | х                   | х                  |      |          |
| Бэлчээр ашиглалтанд үзүүлэх нөлөө                                                                                                                       | х                |          |                     |                    | х    |          |
| Нөлөөллийн хуримтлагдах байдал                                                                                                                          |                  |          |                     |                    |      |          |
| Төслийн үргэлжлэх хугацаа богино                                                                                                                        | х                |          |                     | х                  |      |          |
| Нөхөн сэргээгдэх бүрэн боломжтой                                                                                                                        |                  | х        |                     |                    | х    |          |
| Дүн                                                                                                                                                     |                  |          |                     |                    |      |          |


# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН НУТАГТ ОРШИХ ТОЛГОЙТ-1 ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## 4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛТ

Толгойтын хөндийн Толгойт-1 алтны шороон ордыг ашиглах төслийн баримт бичигт туссан гол зорилго, техник, технологи, эдийн засгийн хүчин чадал, үндсэн болон туслах үйл ажиллагааны хамрах хүрээ, онцлогийг дээр тодорхойлсон бөгөөд үүнд үндэслэн давхцуулан зураглах арга, Магадлан жагсаах аргыг ашиглан байгаль орчны шинжилгээ хийж, гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн эх үүсвэрийг тодорхойлов.

Ил уурхайн оновчлолоор үүссэн хүрээнд 136.42 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 13.11 мян.м<sup>3</sup> элс олборлохоор байна. Иймд энэ хүрээнд олборлох, баяжуулах үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг тооцоолох, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зөвлөмж боловсруулах нь энэхүү байгаль орчны нөлөөллийн үнэлгээний зорилго юм. Дараах зурагт уурхайн төлөвлөлтийг хиймэл дагуулын зураг дээр тайлбарлан оруулсан.

Өмнөх хугацаанд явагдсан уул уурхайн олборлолтын үйл ажиллагаагаар нутгийн ландшафтын хэв шинж өөрчлөгдсөн байна. Толгойтын хөндийн Толгойт-1 алтны шороон ордын газар ашиглалтыг дараах хүснэгтэнд харуулав.




Зураг 5. Газар ашиглалт

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН НУТАГТ ОРШИХ ТОЛГОЙТ-1 ОРДЫН 2025  
ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

*Хүснэгт 10. Уурхайн объект, түүний талбай*

| № | Уурхайн олборлолт баяжуулалтаар үүссэн объект /одоогийн байдлаар/ | Талбай, га | №  | Уурхайн олборлолт баяжуулалтаар үүсэх объект | Талбай, га |
|---|-------------------------------------------------------------------|------------|----|----------------------------------------------|------------|
| 1 | Хөрсийн овоолго                                                   | 7.29       | 6  | Ил уурхай                                    | 0.57       |
| 2 | Зам                                                               | 0.78       | 7  | Цэвэр усны нуур                              | 0.5        |
| 3 | Уурхайн тосгон                                                    | 0.25       | 8  | Бохир усны нуур                              | 0.02       |
| 4 | Хиймэл нуур                                                       | 8.63       | 9  | Уурхайн тосгон                               | 0.07       |
| 5 | Нөхөн сэргээлт хийсэн талбай                                      | 7.38       | 10 | ШТС                                          | 0.002      |
|   | Нийт                                                              | 24.34      | 11 | Элс болон эфель галийн овоолго               | 0.08       |
|   |                                                                   |            | 12 | Зам                                          | 1.8        |
|   |                                                                   |            | 13 | Овоолсон шороо                               | 11.1       |
|   |                                                                   |            | 14 | Угаах төхөөрөмж                              | 0.04       |
|   |                                                                   |            | 15 | Үүсмэл нуур                                  | 0.7        |
|   |                                                                   |            |    | Нийт                                         | 14.88      |

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөллийн бүсийг урьдчилсан байдлаар тогтоохдоо БОНХСайдын А-117 тоот аргачлалд заасан нөлөөлөл буурах функцийг ашигласан болно. Нөлөөллийн эх үүсвэрүүдийн тэгш хэмт цэгээс хүчтэй нөлөөлөл 0-1000м зайд, дунд зэргийн нөлөөлөл 1000-1400 м зайд, бага нөлөөлөл 1400-2200 м зайд тус тус үүсэх магадлалтай юм



*Зураг 6. Төслийн нөлөөллийн бүс*

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН НУТАГТ ОРШИХ ТОЛГОЙТ-1 ОРДЫН 2025  
ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

БОНХСайдын А-117 тоот аргачлалд заасан үзүүлэлтээр байгаль орчны шинжилгээ хийж үр дүнг дараах хүснэгт 11-д үзүүлэв.

*Хүснэгт 11. Байгаль орчны шинжилгээ*

| №                    | Байгаль орчны шинжилгээ хийх асуултууд                                                                                                                                | Тийм | Үгүй |
|----------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------|
| 1                    | Газрын гадаргын хэв шинжид гарах өөрчлөлт                                                                                                                             | +    |      |
| 2                    | Газар ашиглалтын өөрчлөлт                                                                                                                                             | +    |      |
| 3                    | Төсөл хэрэгжүүлэх зориулалтаар усны нөөцийг ашиглах эсэх                                                                                                              | +    |      |
| 4                    | Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх эсэх                                                                                                           | +    |      |
| 5                    | Үл нөхөн сэргэх болон байгалийн ховор нөөц, баялгийг ашиглах эсэх                                                                                                     | +    |      |
| 6                    | Тухайн төслийг хэрэгжүүлэх хүрээнд хүний эрүүл мэнд байгаль орчинд хор хөнөөлтэй химийн бодис материалыг ашиглах хадгалах тээвэрлэх устгах үйл ажиллагаа явагдах эсэх |      | +    |
| 7                    | Тухайн төслийг хэрэгжүүлэх хүрээнд хүний эрүүл мэнд байгаль орчинд хор хөнөөлтэй химийн бодис материалыг үйлдвэрлэх үйл ажиллагаа явагдах эсэх                        |      | +    |
| 8                    | Төслийн барилга байгууламжийг барьж байгуулах төсөл хэрэгжүүлэх болон хаалтын үе шатанд хатуу хог хаягдал гарах эсэх                                                  | +    |      |
| 9                    | Төслийн барилга байгууламжийг барьж байгуулах төсөл хэрэгжүүлэх болон хаалтын үе шатанд шингэн хаягдал /бохир ус / гарах эсэх                                         | +    |      |
| Орчны бохирдол       |                                                                                                                                                                       |      |      |
| 10                   | Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор аливаа төрлийн бохирдуулагч болон аюултай хортой бодис агаар мандалд ялгарах эсэх                                                  | +    |      |
| 11                   | Дуу шуугианы нөлөө                                                                                                                                                    | +    |      |
| 12                   | Чичиргээний нөлөө                                                                                                                                                     | +    |      |
| 13                   | Дулааны нөлөө                                                                                                                                                         | +    |      |
| 14                   | Цахилгаан соронзон долгионы нөлөө                                                                                                                                     |      | +    |
| 15                   | Цацрагийн нөлөө                                                                                                                                                       |      | +    |
| 16                   | Гадаргын болон газрын доорхи усанд бохирдуулагч бодис нэвчих үед усны бохирдол үүсэх эсэх                                                                             | +    |      |
| Эрсдэлийн үнэлгээ    |                                                                                                                                                                       |      |      |
| 17                   | Хүний эрүүл мэнд аюулгүй байдалд үүсэх эрсдэл                                                                                                                         | +    |      |
| 18                   | Байгаль орчинд үүсэх эрсдэл                                                                                                                                           | +    |      |
| Нийгэм – эдийн засаг |                                                                                                                                                                       |      |      |
| 19                   | Төслийн хэрэгжилттэй холбоотойгоор нийгэмд тодорхой өөрчлөлт гарах эсэх                                                                                               | +    |      |
| 20                   | Хүн амын амьжиргааны түвшин өөрчлөгдөх                                                                                                                                | +    |      |
| 21                   | Бизнесийн таатай орчин бүрэлдэх                                                                                                                                       |      |      |
| 22                   | Орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх                                                                                                                                  | +    |      |
| 23                   | Шинээр ажлын байр бий болгох                                                                                                                                          | +    |      |
| 24                   | Орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх                                                                                                                                  | +    |      |
| 25                   | Хөдөлмөр эрхлэнлтэнд өөрчлөлт гарах                                                                                                                                   | +    |      |

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН НУТАГТ ОРШИХ ТОЛГОЙТ-1 ОРДЫН 2025  
ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

|    |                                                                                                                                                                                              |   |   |
|----|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|---|
| 26 | Тухайн орон нутгийн оршин суугчдын зан үйл шашин шүтлэг зэрэгт                                                                                                                               |   | + |
| 27 | Тухайн орон нутгийн оршин суугчдын дасан зохицсон амьдралын хэв маягт сөргөөр нөлөөлөх                                                                                                       | + |   |
| 28 | Хөгжлийн хэтийн төлөвлөгөө тухайн үед орон нутагт хэрэгжиж байгаа буюу хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаатай холбоотойгоор үүсч болзошгүй сөрөг нөлөөлөл бусад хүчин зүйл байгаа эсэх |   | + |
| 29 | Байгаль орчны бохирдол доройтол үүсгэж болзошгүй зам тээврийн үйл ажиллагаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэр түүний ойр орчимд явагдах эсэх                                                      | + |   |

Дээрх байгаль орчны шинжилгээний үр дүнг үндэслэн байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн эх үүсвэр болон нөлөөлөлд өртөгдөх байгаль орчин, нийгэм эдийн засгийн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлохдоо “Магадлан жагсаах арга”-ыг ашиглав. (Хүснэгт 12) НҮБХХБ болон Байгаль орчин аялал жуулчлалын яамны хамтран хэрэгжүүлж буй Монгол улсын Байгаль орчны засаглалыг бэхжүүлэх нь төслийн хүрээнд боловсруулсан аргачлалд заасан магадлан жагсаах аргын хувилбарыг нөлөөллийн эх үүсвэр, тэдгээрт өртөгдөх байгаль, нийгэм, эдийн засгийн хам бүрдлийг тодорхойлоход ашигласан болно.

